Ходоодонд орших бадганы хорхойн хэлбэр, өвчнийх нь шинжийг Helicobacter pylori (H.pylori) -той харьцуулан, өргөн хэрэглэгдэж ирсэн Руда-6 жорынх нь *H.Pylori*-н эсрэг судлагдсан байдлыг тодруулсан нь

С.Сээсрэгдорж[1], С.Цээлээ[2]

[1]АШУҮИС, МАУОУС, Дотор өвчин судлалын тэнхим
[2]АШУҮИС, МАУОУС, УА-ын 6 дугаар дамжаа
Цахим шуудан: seesregdorj@mnums.edu.mn, Утас: 99296858

Түлхүүр үг:

H.Pylori
Бадган хорхой
Руда-6
Сурвалж судлал
Уламжлалт эмчилгээ

Товч утга:

Үндэслэл: Монголын уламжлалт анагаах ухааны өвчин үүсгэх шалтгааны нэг болох ходоодонд орших бадганы хорхойг *H.Pylori*-тай харьцуулан авч үзэх нь шинэлэг сонирхолтойн зэрэгцээ цаашид *H.Pylori*-н шалтгаант ходоодны үрэвслийг уламжлалт аргаар хавсруулан эмчлэх боломж нээгдэх юм гэж үзлээ. **Зорилго:** Ходоодонд орших бадганы хорхойн хэлбэр, түүний өвчин үүсгэх жам, шинж тэмдгийг *H.Pylori*-той харьцуулан бадганы хорхойн эмчилгээнд хамгийн өргөн хэрэглэгдэж ирсэн зарим жорын *H.Pylori*-н эсрэг судлагдсан байдлыг тодруулах. **Арга, аргачлал:** Эх бичиг, сурвалж судлалын магадлан жагсаах, нэгтгэн дүгнэх, аргыг ашиглан, “Анагаах ухааны дөрвөн үндэс” сурвалж, Манаглхантав, Бидэр-Онбо тайлбарууд, “Маш гайхамшигт хуримын сан” “Шүрэн таяг”, “Нандин эрдэнийн шимийн хураангуй” зэрэг монгол мэргэдийн бүтээлүүд болон PubMed, Science Direct, Google scholar зэрэг цахим сангуудыг ашиглан судаллаа. **Үр дүн:** Бичил дуран хөгжөөгүй I-II зуунд хамаарагдах уламжлалт сурвалж, тайлбарт ходоодонд орших бадганы хорхой нь түүдэг боосон адил хэлбэртэй, зарим нь мушгиралдан өт буцалж байх мэт, зарим нь нарийхан урт жижиг гэж хэлбэр дүрсийг тодорхой заасан нь *H.pylori*-г орчин үед микроскопын тусламжтай спирал хэлбэртэй, 5x3 микрометр хэмжээтэй, мөн морфлогийн S U C хэлбэртэй гэж үзэж байгаатай дүйхээр байна. Уламжлалт сурвалжуудад бадганы хорхойн өвчин үүсгэх идээ, ундааг амтлаг амт хийгээд сүү гэж олон давтамжтай заасан нь *H.pylori* нь уреза фермент ялгаруулан ходоодны хүчлийг саармагжуулах болон сүүн бүтээгдэхүүн дэх казеин, кальци нь тунадасжин ходоодны салиаг өтгөрүүлснээр *H.pylori*-ийн амьдрах таатай нөхцлийг бүрдүүлдэг гэж заасантай тохирч байна. Уламжлалт эх сурвалжуудад дах нийтлэг шинжүүд нь *H.Pylori* -ийн халдварын үед ходоод хэвлийн хэсгээр халуу дүүгэж өвдөх, дотор муухайрах, хэхэрч огиулах, хоолны дуршил буурах, гэдэс дүүрч хоржигнох, шалтгаангүй жин хасах зэрэг шинжүүдтэй дүйж байна. Уламжлалт сурвалж, тайлбар бүтээлүүдэд ходоодны бадганы хорхойн өвчний эмийн эмчилгээнд олон давтамжтай бичигдсэн Руда-6 жорыг цус шарын халууныг арвидуулахгүйгээр бадган хийг дарж, бадган бор харшилдсан, цанх, хэхрэх, бөөлжих, ходоодны хатгалгыг анагаах үйдэлтэй гэж үздэг. Энэ нь тус найрлагын бүрэлдэхүүн дэх Рудагийн дегидрокостус лактон, Жүр үр дэх генипин, Бибилин, Сүгмэл, Башигын этанолын ханд нь эмнэлзүйд өргөн тохиолдох зургаан омгийн *H.pylori*-н өсөлтийг зогсоох, *H.pylori*-н уреза ферментийн идэвхийг саатуулах, *H.pylori*-г ходоодны эсэд бэхлэгдэхийг хориглох замаар ходоодны эсийг хамгаалах зэрэг *H.Pylori*-н эсрэг олон талт үйлдэлтэй нь туршилт судалгаагаар тогтоогдоод байгаа нь тус уламжлалт жорын үйдлийг батагтахын хамт *H.pylori* халдварын хүндрэлээс урьдчилан сэргийлэх боломжтойг харуулж байна. **Дүгнэлт:** 1. *H.Pylori*-той бадганы хорхойг харьцуулж үзвэл орших орон нь нэг адил ходоод болох ба *H.Pylori* нь спираль хэлбэртэй, шилбүүртэй болох нь тогтоогдсон байдаг нь уламжлалт анагаах ухаанд ходоодны хорхойг түүдэг боосон адил, мушгиралдсан урт нарийхан хэлбэртэй нь дүйлгэн авч үзэх боломжтой байна. 2. Ходоодны бадганы хорхойн өвчний нөхцөл нь амтлаг амттай идээ ундаа хэмээн заасан нь *H.pylori*-н шүлтлэг орчинд өсөн үржиж өвчлөл үүсгэдэгтэй адил бөгөөд *H.Pylori* болон бадганы хорхойн өвчин болсон үед илрэх шинж тэмдгээрээ дүйцэж байна. 3. Руда-6 найрлагын бүрэлдэхүүнд орж байгаа эмийн түүхий эдүүд нь *H.Pylori*-г дарангуйлах хүчтэй нөлөөтэй байгаа нь уг халдварын шалтгаант өвчлөлийн үед уламжлалт эмийн эмчилгээ гаж нөлөө багатай, үр дүнтэй эмчилгээний нэгэн хувилбар байж болохыг харуулж байна.

Үндэслэл: *H.pylori*-г анх 1982 онд Австралийн эрдэмтэд Бэрри Маршал болон Робин Варрен нар хүний ходоодны салстаас өсгөвөрлөж "Ходоодны ихэнх үрэвсэл, шархны шалтгаан нь стресс болон халуун ногоо биш харин энэхүү нянгийн халдвар" гэж анагаах ухаанд нэгэн нээлт хийсэн бөгөөд ходоодны биж хам шинжээр илэрч ходоодны шарх, шархлаа, MALT лимфома улмаар ходоодны хорт хавдар үүсгэх эрсдэлт канцорген хүчин зүйл хэмээн ДЭМБ тодорхойлоод байна. Манай орны хувьд нийт хүн амын 76%-д уг халдвар тодорхойлогддог нь халдвар өндөртэй орны тоонд ороход хүргэж буй бөгөөд уг халдварыг Маастрихтын удирдамжийн дагуу 2 антибиотик хосолсон гурвалсан болон дөрвөлсөн эмийн эмчилгээний зааврааар эмчилдэг[1]. Гэхдээ антибиотик эмчилгээнд ходоод өвдөх, дотор муухайрах зэрэг шинж илрэхийн хамт бичил орчны тэнцвэрийг алдагдууллах зэрэг биед үзүүлэх гаж нөлөө өндөртэй мөн эмчилгээний дараа ч дахин халдвар авах эрсдэлтэй байсаар байдаг нь энэхүү эмийн эмчилгээний үр дүнг бууруулж байна[2]. Харин Монголын уламжлалт анагаах ухаанд өвчин үүсгэх үндсэн шалтгааныг өнө эртнээс хий, шар, бадган, цус, шар ус, хорхой хэмээн үзэж ирсэн бөгөөд ходоодонд орших бадганы хорхой өвчин үүсгэгдгийг H.Pylori-тай харьцуулан судлах нь шинэлэг сонирхолтойн зэрэгцээ цаашид H.Pylori-ийн талаар шинэ агуулгаар авч үзэх төдийгүй түүний шалтгаант ходоодны үрэвслийг уламжлалт аргаар хавсран эмчлэх өргөн боломж нээгдэх юм хэмээн үзлээ.

Зорилго: Ходоодонд орших бадганы хорхойн хэлбэр, түүний өвчин үүсгэх жам, шинж тэмдгийг *H.Pylori*-той харьцуулан бадганы хорхойн эмчилгээнд өргөн хэрэглэгдэж ирсэн зарим жорын *H.Pylori*-н эсрэг судлагдсан байдлыг тодруулах.

Зорилт:

1. Уламжлалт сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдэд заасан ходоодны хорхойн хэлбэр байдлыг *H.Pylori*-н тогтоосон хэлбэртэй харьцуулах
2. Бадганы хорхойн өвчин үүсгэх эмгэг жам, шинжүүдийн талаар уламжлалт зарим сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдээс судлан *H.Pylori*-той харьцуулах
3. Ходоодны бадганы хорхойн эмчилгээнд өргөн хэрэглэдэг Руда-6 жор түүний бүрэлдэхүүний түүхий эдүүдийн *H.Pylori*-д үзүүлсэн нөлөөг тодруулах

Арга, аргачлал: Судалгааг эх бичиг, сурвалж судлалын магадлан жагсаах, харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг ашиглан *"Эм заслын саран хаан* (1-2-р зуун)[3]", "Бонши (гарсан он тодорхойгүй)[4] "Анагаах ухааны дөрвөн үндэс (8-р зууны дунд үе)[5] сурвалжууд, "Бидэр-Онбо (Дэсрид Санжаажамц-1640 он)[6]", "Манаглхантав (Дэсрид Санжаажамц-1691 он)[7]" тайлбарууд, "Дөрвөн Рашаан (Ишбалжир-1785 он)[8]" Жамбалчойжиданзандэрэнлэйн "Увдисын далай" (Жамбалчойжиданзанпэрэнлэй-1826 он)[9], "Шүрэн таяг (Ишданзанвааанжил-1868 он)[10], "Нандин эрдэнийн шимийн хураангуй (Лувсанчоймбол-19-р зуун)[11]", "Маш гайхамшигт хуримын сан (Чойжамц-1921 он)[12]", зэрэг монгол мэргэдийн бүтээлүүд болон *PubMed, Science Direct, Google scholar, Scopus* зэрэг цахим сангуудаас харьцуулан судаллаа.

Үр дүн: "Эм заслын саран хаан" сурвалжийн хорхойн бэлгэ чанарыг өгүүлэх 47 дугаар бүлэгт боодол уясан адил хэлбэртэй бадганы хорхой нь ходоодонд оршино, "Бонши" сурвалжийн цанх өвчний 52 дугаар бүлэгт: Бадганын хорхой нь түүдэг мэт ходоодонд оршмуй хэмээсэн бөгөөд, АУДҮ болон Бидер онбо бүтээлийн Цанхыг анагаах 49 дугаар бүлэг, Хорхойн өвчнийг анагаах 50 дугаар бүлэг, Хорхойн өвчнийг анагаах 7 дугаар бүлэгт: Ганц бадганы хорхойг зарим нь мушгиран барилдсан адил, зарим нь хорхой буцлах адил нарийн урт, цагаан, улаан үзэгдэлтэй байна гэж олон зүйлээр тодорхойлоод хямарсан орондоо дангаараа болон хавсарсан, хурсан өвчний зүйл болно хэмээгээд аль орны хорхой байна тус тусынхаа оронд хорхойн өвчин үүсгэх бөгөөд бадганы хорхой нь түүдэг боосон адил ба ходоодонд оршино хэмээн гадна байдлыг адил утгатай тодорхойлжээ (Зураг 1). *H.pylori*-н гадна байдлыг орчин үед микроскопын тусламжтай спирал буюу мушгирсан хэлбэртэй, грам сөрөг, 5x3 микрометр хэмжээтэй, нэг талын төгсгөлдөө 4-6 ширхэг шилбүүртэй ба түүнийхээ тусламжтай хөдөлдөг гэж тодорхойлоод байна (Зураг 2)**.**



Зураг. 1 Уламжлалт сурвалжуудад бадганы хорхойг мушгиралдсан, түүдэг боодол уясан адил хэлбэртэй гэж тодорхойлсон



Зураг. 2 *H.pylori*-г электрон микроскопоор 10,000 дахин өсгөсөн микрограф зураг

Уламжлалт анагаах ухаанд бадганы хорхойн өвчин үүсгэх нөхцлийг идээ ундаатай холбон тайлбарласан бөгөөд үүнд амтлаг амттай, цагаан идээний зүйлийг онцолсон ба Манаглхантав, Бидер-Онбо, Маш гайхамшигт хуримын сан бүтээлүүдэд Адын нөхцөлөөр үүсэж болох талаар нэмэлт хийсэн нь онцлог байлаа. Орчин үеийн Био-Анагаахын судалгаагаар *H.Pylori*-н халдвар авсан тохиолдол бүрт шинж тэмдэг илрэхгүй байж болох ба энэ нь хувь хүний дархлааны онцлог, хооллолтын байдлаас шалтгаалдаг бөгөөд сүү сүүн бүтээгдэхүүн, чихэрлэг амттан зэргийг түлхүү хэрэглэснээр ходоодны хүчил саармагжих нөхцөл бүрдэн *H.Pylori* идэвхждгийг тогтоосон[13] нь биед орших бадганы хорхой нь өөрөө өвчний шалтгаан болж дээрх чанарын идээ ундааны нөхцөлөөр өвчин үүсгэн үйлддэг гэсэнтэй дүйж байдаг (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Өвчин үүсгэх нөхцлийн талаар эх сурвалжуудаас тодруулсан байдал

Өвчин үүсгэх нөхцөл	Эх сурвалж
Идээ ундаа: цагаан идээ амтлаг, хүчиллэг тэргүүтнийг арвин идсэн	Эм заслын саран хаан (1-2-р зуун) 47-р бүлэг Хорхойн бэлгэ чанар
Идээ ундаа: цагаан идээ, амтлаг идээ Явдал мөр: даарсны дараа өвдөх, хүйтний нөхцөл	АУДҮ (8-р зуун) Цанхыг анагаах 49-р бүлэг, Хорхойн өвчнийг анагаах 50-р бүлэг
Идээ ундаа: идээ явдал дутуудаж илүүдэх буруудах, Цагаан идээний зүйл ба жимсний зүйл	Бидер-Онбо (1640 он) Хорхойн өвчнийг анагаах 7-р бүлэг
Идээ ундаа: цагаан идээ, амтлаг идээ, шарсан хольсон идээ Явдал мөр: даарсны сүүлд өвдөх, хүйтэн гал нар утаа Бусад: Ад	Манаглхантав (1690 он) Ерөнхий цанх Хорхойн өвчнийг анагаах 74, 75-р бүлэг Нян хижиг ходоодны цанхыг засах 33-р бүлэг
Идээ ундаа: Үл тохирсон идээ Явдал мөр: даарсан Бусад: Ад	Маш гайхамшигт хуримын сан (1921 он) Хорхой, цанхыг анагаах 70,71-р бүлэг
Нөхцөл: ариун бус явдал болон урьдын муу үйл явдлууд	Шүрэн таяг (19-р зуун) Нян цанх өвчнийг засах 78-р бүлэг
Идээ ундаа: цагаан идээ, амтат идээ Явдал мөр: даарсны дараа	Нандин- Эрдэнийн шимийн хураангуй 19-р зуун) 10-р бүлэг цанхыг анагаах

H.Pylori нь ходоодны салст бүрхэвчийн эсийг гэмтээж, ходоодны салстын шарх, шархлаа улмаар ходоодны хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл болох ба ходоод хэвлийн хэсгээр халуу дүүгэж өвдөх, дотор муухайрах, хэхэрч огиулах, хоолны дуршил буурах, гэдэс дүүрч хоржигнох, шалтгаангүй жин хасах зэрэг шинж тэмдгээр илэрдэг нь уламжлалт сурвалж тайлбаруудад заасан дээрх шинжүүдтэй дүйж байна. Мөн уламжлалт анагаах ухааны сурвалж бүтээлүүдэд шар үс урвах, чих навтайх, нүдний сормуус нь доош буух болон өвдөлтийн хүч их байхаар заасан нь ялгаатай байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Өвчний шинж тэмдгийн талаар эх сурвалжуудаас тодруулсан үр дүн

Анагаах ухааны дөрвөн үндэс (8-р зууны дунд үе)	- Хутгаар хутгалж байх шиг ходоод эвхрэн өвдөх - Булчин нь нарийсан, шар үс нь ургах - Чихний мөгөөрс зөөлөрч сормуус нь буух - Хэвлий хөөсөн шиг болж тэлэгдэж өвдөх
“Бидэр-Онбо (Дэсрид Санжаажамц-1640 он)”	- Өвчүү халж цоргих шиг болон хутгаар хэрчиж байх мэт өвдөх - Булчингийн гол борлож, шар үс урвах, чих навтайх, нүдний сормуус нь доош буух - Судлын тамир буурах - Гэдэсний мөрийн баас хаагдах
“Манаглхантав (Дэсрид Санжаажамц-1691 он)”	- Ходоод өвдөх цагт хутгаар дүрэх адил эрчилж хуйлран өвдөх - Булчин урваад буурна, шар үс сөрнө - Түүдэг мэт ороолдох буюу цоорох мэт санагдана. - Бие хөлрөөд доод хий хурна
“Дөрвөн Рашаан (Ишбалжир-1785 он)”	- Ходоодыг хутгаар хутгалж байгаа мэт эрчилж өвдөх - Дөрвөн мөчний булчингууд мушгиралдан өвдөх - Сормуус дотогш хураагдан шар үс гүрвийх
“Маш гайхамшигт хуримын сан (Чойжамц-1921 он)”	- Эвхэртэл хатгуулж өвдөх - Бөөлжих

Уламжлалт анагаах ухаанд тус жорыг хоол боловсруулах замын өвчлөлд өргөн ашиглаж ирсэн бөгөөд түүний бүрэлдэхүүний Сүгмэлийг хоолны шингэц сайжруулах, биед шим авахуулах, Жүр үрийг махбодыг тэгшитгэх, нян устгах, үрэвсэл намдаах, Рудаг бадганыг арилгах, өвдөлт намдаах, ходоодны цанх, хэрэх, бөөлжих, ходоод өвдөх зэрэгт, Бибилинг илчийг сэлбэж хоолны дурыг нээх, хүйтэн өвчнийг анагааж эс шингэснийг дарах, Сэмбэрүүг ходоодны өвчнийг арилгах, галын илчийг үүсгэж бадган хийн өвчин бүхний суурийг тэгшитгэх үйлдэлд нь үндэслэж найруулсан нь ходоодны бадганы хорхой түүнээс үүсэх өвчний эмгэг жам, илрэх шинжүүд, хүндрэлээс урьдчилан сэргийлэх өргөн хүрээний үйлэлтэй байгаа нь өвчний шалтгааны эсрэг чиглэсэн амт, чадал, шингээлтэд суурилсан болохыг харуулдаг[20] (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Руда-6 жорыг эх сурвалжуудад заасан байдал

РУДА-6 нь цус шарын халууныг арвидуулахгүйгээр бадган хийг дарж, бадган бор харшилдсан, цанх, хэхрэх, бөөлжих, ходоод хатгалах зэргийг анагаах чадалтай	
Манаглхантав (Дэсрид Санжаажамц-1691 он)	Ходоодны өвчний зүйл бүхэнд, нян цанхын цагт руда-6.
АУДҮ(8-р зууны дунд үе), Маш гайхамшигт хуримын сан (Чойжамц-1921 он)	Бор харшилдсан хорхойн цанх өвчнийг анагаана.
АУ-ны тус амгалангийн эрдэнийн хөмрөг	Руда-6-г нэмэр хачир бүхнээр нэмэрлэн хорхойн нян цанх өвчин бүхнийг эдгээнэ.
Увдисын далай (Жамбалчойжиданзанпэрэнлэй-1826)	Руда-6-н дээр гарво нэмснээр зуун өвчнийг арилгах нэг эм болох ба цанхын язгуур бүгдэд тусална.

Орчин үеийн анагаах ухааны судалгаагаар уг жорын найрлага дах түүхий эдүүдийн *H.pylori*-н эсрэг нөлөө дараах байдлаар тогтоогдоод байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Руда-6 жорын түүхий эдүүдийн H.pylori-н эсрэг судлагдсан байдал

Руда (*Saussurea lappa L.*)	*H.pylori*-н өсөлтийг зогсоох, ходоодны салстыг төлжүүлэх[14]
Бибилин (*Piper longum L*)	*H.pylori*-г үхүүлэх, өсөлтийг нь зогсоох, нянгийн ходоодны эсэд бэхлэгдэхийг саатуулах, ходоодны үрэвсэл дарж шархны эдгэрэлтийг түргэсгэх[15]
Сүгмэл *(Elletaria cardamomum White)*	*H.pylori*-н өсөлтийг зогсоох, антиоксидант, үрэвслийн эсрэг[16]
Анар *(Punica granatum)*	*H.pylori*-н гадаргуугийн гидрофобик чанарыг өөрчлөх замаар нянг ходоодны эсэд бэхлэгдэхийг саатуулна. *H.pylori*-н уреза ферментийн идэвхийг сулруулна. Ходоодны үрэвслийн эсрэг[17]
Башига *(Odontites rubra)*	Өвдөлт намдаах, ходоодны хямрал, гэдэс дүүрэх зэрэг хоол боловсруулах эрхтний өвчнийг эмчлэх.[18]
Жүр үр *(Gardenia Jasminoides)*	*H.pylori*-н өсөлтийг саатуулах, ходоодны эсэд бэхлэгдэхийг дарангуйлах, үрэвсэл намдаах, ходоодны AGS, SUN638 хорт хавдрын эсрэг, антиоксидант, ходоодны шархыг нөхөн төлжүүлэх[19]

Хэлцэмж: Бадганы хорхойн зарим нь мушгиралдсан, зарим нь өт буцалж байх мэт, зарим нь нарийхан урт бөгөөд жижиг, зарим нь цагаан зарим нь улаан байдаг хэмээн эх сурвалжуудад заасан бол H. pylori-н омгийн төрлийг иммуноблотын аргаар CagA (VacA эсрэгбие, ПГУ-аар cagA) vacA ген байгаа эсэхэд тулгуурлан I омог хоруу чанар өндөртэй а бүлэг, хоруу чанар дундаж b бүлэг, II омог буюу хоруу чанар буурсан бүлэг гэж ангилахаас гадна морфлогийн хэлбэрээр нь S U C хэлбэртэй гэж ангилж буй нь уламжлалт анагаах ухаанд олон зууны өмнөөс бичил дуран бүтээгдээгүй үед ходоодонд орших бадганы хорхойн хэлбэр, дүрсийг тодорхойлсон байдал нь орчин үед *H.pylori*-н хэлбэр дүрсийг ялгаж тогтоосонтой гадаад байдлын хувьд төстөй байгаа нь сонирхолтой юм[21].

Уламжлалт сурвалжуудад бадганы хорхойн өвчин үүсгэх нийтлэг нөхцөлөөр амтлаг амттай идээ ундааг авч үзсэн бөгөөд амтлаг амт нь шороо усан махбодын мөн чанартай холбоотой ходоодны бадган салсыг арвидуулан шингээгч шарын галын илчийг доройтуулах эмгэг жамтай байдаг бол хеликобактер нь уреза фермент ялгаруулан ходоодны хүчлийг саармагжуулж өөрийн орших таатай нөхцлийг бүрдүүлдэгтэй дүйж байгаа төдийгүй *H.pylori* нь 2-р хэлбэрийн чихрийн шижинтэй өвчтөнүүдэд чихрийн шижингүй өвчтөнүүдээс илүү түгээмэл байдаг гнх судалгаатай тохирч байна[22].

"Түүнчлэн сүү, сүүн бүтээгдэхүүн их хэмжээгээр хэрэглэх нь *H.pylori* халдварын хүчин зүйл болдог"-ийг казейноген нь ходоодны хүчил, рениний нөлөөгөөр казеин болон задарч мөн сүүн дэх кальци нь тунадасжин ходоодны салиаг өтгөрүүлснээр *H.pylori*-ийн амьдрах таатай нөхцлийг бүрдүүлдэг гэж үзэж байгаатай "Эм заслын саран хаан", "АУДҮ", "Манаглхантав" болон бусад эх сурвалжуудад өвчин үүсгэх идээний нөхцөлд хамгийн олон давтамжтай цагаан идээг заасан нь эмгэг жамын хувьд таарч байна[5,7,13].

Мөн "Манаглхантав" тайлбарт өвчин үүсгэх

идээ ундааны нөхцөлд шарсан хольсон идээг оруулсан нь *H.pylori* халдвар нь шарсан хайрсан хоол идэхтэй хамааралтай[23] гэсэн дүгнэлттэй тохирч байгаа төдийгүй исгэлэн жимснүүд ялангуяа нимбэг, жүрж, хан боргоцой зэрэг нь *H.pylori* болон бусад шалтгаант ходоодны өвдөлт үрэвсэлд муугаар нөлөөлдгийг тогтоосон нь "Бидер-Онбо" тайлбарт жимс гэж заасантай дүйж байна[24].

Эмнэлзүйн судалгаагаар Руда-6 жор нь TNF-α, iNOS,-ийн түвшинг бууруулан индометацинаар өдөөгдсөн ходоодны шархны эдгэрэлтэд ихээхэн үр дүнтэй ($p<0.05$) мөн үрэвслийн эсрэг болон антиоксидант шинжээрээ ходоодны үрэвсэлд үр дүнтэй, ходоодны үрэвслийн үед ходоод гэдсэнд дэх бичил биетний тэнцвэрт байдал алдагддаг ба Руда-6 нь тэрхүү бичил орчныг тэнцвэржүүлж ходоодыг хамгаалаад зогсохгүй Руда-6 нь сийвэнгийн метаболитуудыг зохицуулахад оролцдог амин хүчил, органик хүчлүүдийн түвшинг зохицуулдаг зэрэг үйлдлүүд нь тогтоогдсон байдаг нь тус уламжлалт жорыг *H.pylori* халдварын үед хавсруулан хэрэглэх төдийгүй түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэх боломжтойг харуулж байна[25].

Уламжлалт анагаах ухаанд *H.pylori*-г олон зууны өмнөөс илрүүлж таньж мэдээд өөрийнхөө онол, арга зүйн хүрээнд түүний шалтгааны эсрэг эмчилгээг цогц нэгдмэл чанартай бий болгож баяжуулж, хөгжүүлж ирснийг өнөө цагт тулгамдаад буй хеликобактерийн эмчилгээтэй хавсруулан хэрэглэх төдийгүй тэдгээрийг судлаж нотолгоожуулах нь эмнэлзүйн ач холбогдол ихтэй байна.

Дүгнэлт:

1. Ходоодны бадганы хорхойг *H.Pylori*-той харьцуулж үзвэл орших орон нь нэг адил ходоод болох ба түүнийг спираль хэлбэртэй, шилбүүртэй, морфлогийн хэлбэрээр нь S U C гэж тогтоосныг уламжлалт анагаах ухаанд ходоодны хорхой түүдэг боосон адил, мушгиралдсан урт нарийхан хэлбэртэй гэж тодорхойлсонтой дүйлгэн авч үзэх боломжтой байна.
2. Ходоодны бадганы хорхойн өвчний нөхцөл нь амтлаг амттай идээ ундаа хэмээн заасан нь *H.pylori*-н шүлтлэг орчинд өсөн үржиж өвчлөл үүсгэдэгтэй тохирч байгаа төдийгүй *H.Pylori* болон бадганы хорхойн өвчний үед илрэх шинжүүдийг дүйлгэж үзэх боломжтой байна.
3. Ходоодны бадганы хорхойн өвчний үед хамгийн өргөн хэрэглэж ирсэн Руда-6 найрлагын бүрэлдэхүүнд орж байгаа эмийн түүхий эдүүд болон түүний жорын талаар хийсэн судалгаанууд *H.Pylori*-г дарангуйлах хүчтэй нөлөөтэй байгаа нь уг халдварын шалтгаант өвчлөлийн үед уламжлалт эмийн эмчилгээ гаж нөлөө багатай, үр дүнтэй эмчилгээний нэгэн хувилбар байж болохыг харуулж байна.

Ном зүй:

1. *Takeshi Matsuhisa, Yoshio Yamaoka, Tomohisa Uchida, Davaadorj Duger, Battulga Adiyasuren, Oyuntsetseg Khasag, Tserentogtokh Tegshee, and Byambajav Tsogt-Ochir. Gastric mucosa in Mongolian and Japanese patients with gastric cancer and Helicobacter pylori infection. World J Gastroenterol. 2015 Jul 21;21(27):8408-17.*
2. *Julia A Bielicki, Wolfgang Stöhr, Sam Barratt, David Dunn, Nishdha Naufal.Effect of Amoxicillin Dose and Treatment Duration on the Need for Antibiotic Re-treatment in Children With Community-Acquired Pneumonia: The CAP-IT Randomized Clinical Trial. JAMA. 2021 Nov 2;326(17):1713-1724.*
3. *"Эм заслын саран хаан (1-2-р зуун(" 47-р бүлэг Хорхойн бэлгэ чанар*
4. *"Бонши (8-р зуун(Цанх өвчнийг анагаах 52-р бүлэг "*
5. *"Анагаах ухааны дөрвөн үндэс (8-р зуун(Цанх анагаах, Хорхойн өвчнийг анагаах 49, 50-р бүлэг*
6. *"Бидэр-Онбо (Санжаажамц-1640 он("Хорхойн өвчнийг анагаах 7-р бүлэг*
7. *"Манаглхантав (Санжаажамц -1690 он(" Ерөнхий цанх Хорхойн өвчнийг анагаах 74, 75-р бүлэг, Нян хижиг ходоодны цанхыг засах 33-р бүлэг*
8. *"Дөрвөн Рашаан (Ишбалжир- 1785 он(" Рашааны дусал үндсэн өвчнийг анагаах бүлэг*
9. *"Увдисын далай (Жамбалчойжиданзанпэрэнлэй-1829(" Зургаадугаар бүлэг, Цанхыг анагаах үес*
10. *"Шүрэн таяг (Ишданзанваанжил-1968 он(", Нян цанх өвчнийг засах 78-р бүлэг*
11. *"Нандин эрдэнийн шимийн хураангуй (Лувсанчоймбол-19-р зуун(" цанхыг анагаах 10-р бүлэг*
12. *"Маш гайхамшигт хуримын сан (Чойжамц-1921 он(" Хорхой, цанхыг анагаах 70, 71-р бүлэг*
13. *J. Danesh. L Youngman, S Clark, S Parish, R Peto, R Collins. Helicobacter pylori infection and early onset myocardial infarction: case-control and sibling pairs study. BMJ. 1999 Oct 30;319(7218):1157-62*
14. *Xuewei Cai, Chunping Yang, Guangwei Qin, Min Zhang, Yan Bi, Xiaoyan Qiu, Liya Lu, and Huabao Chen Antimicrobial Effects and Active Compounds of the Root of Aucklandia Lappa Decne (Radix Aucklandiae) Front Chem. 2022 Apr 6:10:872480*
15. *Rachel O'Mahony, Huda Al-Khtheeri, Deepaka Weerasekera, Neluka Fernando, O'Mahony R, Al-Khtheeri H, Weerasekera D, Fernando N, Vaira D, Holton J, Basset C. Bactericidal and anti-adhesive properties of culinary and medicinal plants against Helicobacter pylori. World J Gastroenterol 2005; 11(47): 7499-7507*
16. *Bhanuz Dechayont, Pathompong Phuaklee., Jitpisute Chunthorng-Orn, Arunporn Itharat. Anti-Helicobacter pylori, anti-inflammatory and antioxidant evaluation of crude extracts from Amomum krervanh fruits. ScienceAsia 2019 45(2):109*
17. *Amal Mayyas, Mohammad Abu-Sini, Rula Amr, Rand T. Akasheh, Waleed Zalloum, Ayman Khdair,Islam Hamad, Talal Aburjai, Rula M. Darwish, and Luay Abu-Qatouseh. Novel in vitro and in vivo anti-Helicobacter pylori effects of pomegranate peel ethanol extract. Vet World. 2021 Jan;14(1):120-128*
18. *Jargalsaikhan Gombodorj, Enkhjargal Bayarsaikhan, Chimedragchaa Chimedtseren, Uuganbayar Baatartsogt, Lhagva-Ochir Tovuu, Anu Altangerel, Lagshmaa Baldoo, Seesregdorj Surenjid. The study of the Mongolian traditional medicine Khurtsiin deed-6 analgesic and anti-inflammatory effect by inhibiting glial cell activation in nitroglycerin-induced migraine in rats. Phytomedicine Plus Volume 3, Issue 1, February 2023, 100388*
19. *Chiung-Hung Chang, Jin-Bin Wu, Jai-Sing Yang, Yen-Ju Lai, Chiu-Hsian Su, Chi-Cheng Lu, Yuan-Man Hsu.The Suppressive Effects of Geniposide and Genipin on Helicobacter pylori Infections In Vitro and In Vivo.J Food Sci . 2017 Dec;82(12):3021-3028*
20. *Б.Хүрэлчулуун, Д.Суран, С.Зина Уламжлалт эмэнд хэрэглэдэг ургамлын түүхий эдийн лавлах 2007 он*
21. *Helena Enroth; Wolfgang Kraaz; Lars Engstrand; Olof Nyrén; Tom Rohan. Helicobacter pylori Strain Types and Risk of Gastric Cancer: A Case-Control Study Cancer Epidemiol Biomarkers Prev (2000) 9 (9): 981–985.*
22. *Seyed Abolfazl Hosseininasab Nodoushan and Amin Nabavi. The Interaction of Helicobacter pylori Infection and Type 2 Diabetes Mellitus. Adv Biomed Res. 2019 Feb 27:8:15.*
23. *Yangchun Zhu, Xiaoying Zhou, Junbei Wu, Jing Su, and Guoxin Zhang. Risk Factors and Prevalence of Helicobacter pylori Infec-*

tion in Persistent High Incidence Area of Gastric Carcinoma in Yangzhong City. Gastroenterol Res Pract. 2014:2014:481365.
24. H, Łukasz; IMIELA, Jacek. Diet and Helicobacter pylori infection. Prz Gastroenterol v.11(3); 2016
25. Lan Feng, Terigele Bao, Laxinamujila Bai, Xiyele Mu, Na Ta, Minglan Bao, Yonghui Li, Junqing Zhang, Minghai Fu, Yongsheng Chen. Mongolian medicine formulae Ruda-6 alleviates indomethacin-induced gastric ulcers by regulating gut microbiome and serum metabolomics in rats. J Ethnopharmacol. 2023 Oct 5:314:116545

Comparative analysis of the Helicobacter pylori (H.pylori) with Dampness-heat pathogens in the stomach and their cause of disease, pathogenesis, symptoms, and clarification of the anti-H.Pylori effects of Ruda-6 recipe

Seesregdorj S[1], Tseelee S[2]

[1]Department of Internal Medicine, International School of Mongolian Medicine, MNUMS
[2]Senior student of the International School of Mongolian Medicine
E-mail: seesregdorj@mnums.edu.mn, Tel:+976-99296858

Background: In Mongolian Traditional medicine, it is fascinating to compare dampness-heat pathogens, which are one of the major causes of disease and conditions in the stomach in Traditional Mongolian Medicine with Helicobacter pylori (*H.Pylori)*, and it is likely to open up a wide opportunity to treat gastritis caused by *H.Pylori* in Western Medicine.
Aim: The main purpose of the study is to compare the form of dampness-heat pathogens in the stomach, its pathogenesis and symptoms with H. Pylori, and clarify the effectiveness of some recipes that have been widely used in the treatment of dampness-heat pathogens against *H. Pylori*.
Materials and Methods: We clarificated dampness-heat pathogens with Helicobacter pylori (*H.Pylori(by* Using the method of summarizing, and listing and comparative analysis of literature the sources of Four medical tantras" (*rGyudbZhi*), the fundamental treatise of Traditional medicine,"Mannaglkhantav", "Bidyer-Onbo" "ngo mtshar dga' ston", "Churu doshil", and "Chuduininnor" and compared with some electronic databases such as PubMed, Science Direct, and Google scholar.
Results: From the traditional sources belonging to the first century, when the microscope was not developed, the dampness-heat pathogens in the stomach are shaped like a bundle, some are twisted, and some are like boiling worms. It is similar to the fact that H. pylori is defined by the microscope as spiral-shaped, 0.5 ×5 μm in length, and it is considered S U C shapes in morphology.*H.pylori* releases the urease enzyme which neutralizes stomach acid, creating suitable conditions for its existence. Dairy is the most frequently mentioned disease factor in traditional sources, and consuming large amounts of dairy products is a factor in *H.pylori* disease. Casein, and calcium from the milk precipitate and thicken gastric mucus, creating suitable conditions for *H.pylori* to grow. The common symptoms of *H.Pylori* infection, which are often duplicated in traditional sources, are similar to symptoms such as burning pain in the stomach and abdomen, nausea, vomiting, loss of appetite, bloating, and unexplained weight loss. According to traditional sources, the Ruda-6 recipe, which is the most often prescribed recipe in the treatment of diseases related to dampness-heat pathogens, is formed to treat stomach "Baoru" disease with indications including anorexia, dyspepsia, acid regurgitation, and gastrointestinal bleeding and pain, which correspond to the symptoms of GU in modern medicine. It contains the dehydrocostus lactone of *Saussurea lappa L*., genipin in *Gardenia Jasminoides*, and the ethanol extracts of *Piper longum L, Elletaria cardamomum White*, and *Odontites rubra*, which compose Ruda-6, can stop the growth of six clinical strains of *H.pylori,* and inhibit the activity of the urease enzyme of *H. pylori* and protecting gastric cells by preventing *H.pylori* from adhering to gastric cells, anti-oxidation, pain and inflammation relief, maintaining the balance of intestinal microflora, and many experimental studies have shown that it has multiple effects against *H.pylori*.
Conclusions:

1. Comparing *H.Pylori* and dampness-heat pathogens, the habitat is the stomach, and H. Pylori has been found to be spiral-shaped, in traditional medicine, dampness-heat pathogens can be considered as a coiled, spiral shaped as well.
2. The condition of dampness-heat pathogens disease, which is indicated as a sweet food and drink, is similar to that of *H.pylori*, which grows and causes disease in an alkaline pH level, and the symptoms of *H.Pylori* and dampness-heat pathogens are similar.
3. The traditional medical sources included in the composition of Ruda-6 have a strong effect of inhibiting *H.Pylori* indicates that traditional drug treatment can be an alternative to effective treatment with fewer side effects.

Keywords: Dampness-heat pathogens, *H.Pylori*, Literature review, Ruda-6, Traditional medicine